



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 25 -ны өдөр

Дугаар А/149

Эрдэнэт

Эрүүл мэндийн яамнаас тусламжаар
ирсэн эм хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.1.4, 10.3.5 дах заалт, иргэний хуулийн 276.6 дах заалт, 2020 оны 02 сарын 05 өдрийн Улсын онцгой комиссын 3-р хурлын тэмдэглэлийн 1.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22 өдрийн 19-р албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах чиглэлээр Эрүүл мэндийн яамаас ирүүлсэн тусламжийн эмийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хуваарийг гарган, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад олгох, баримтжуулахыг нярав /Л.Даваажав/-д үүрэг болгосугай.

3. Хуваарилагдсан эмийн олголт, зарцуулалтад хяналт тавьж зөв зохистой ашиглахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан эмийн хуваарилалт

№	Эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ, нийт тоо ширхэг			БОЭТ		Жаргалант СӨЭМТ	
			Нийт тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Тоо ширхэг	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн
1	Амоксициллин+клавулоны хүчил 1.2гр	ш	30	4,000	120,000	30	120,000		-
2	Левифлоксацин 5мг/мл-100мл	фл	30	7,000	210,000	30	210,000		-
3	Пиперациллин+Тазобактам 4гр+0.5гр	фл	12	18,500	222,000	12	222,000		-
4	Натрийн хлорид 0.9%-250мл	фл	400	1,180	472,000	350	413,000	50	59,000
5	Натрийн хлорид 0.9%-100мл	фл	480	1,235	592,800	400	494,000	80	98,800
6	Рингер лактат 500мл	фл	640	3,150	2,016,000	600	1,890,000	40	126,000
7	Маннитол 250мл	фл	120	3,370	404,400	120	404,400		-
8	Маннитол 500мл	фл	80	4,475	358,000	80	358,000		-
9	Декстроз 5%-250мл	фл	40	1,470	58,800	35	51,450	5	7,350
10	Альбумин 20%-100мл	фл	20	194,000	3,880,000	20	3,880,000		-
11	Допамин 40мг/мл-5мл	амп	20	4,730	94,600	20	94,600		-
12	Добутамин 50мг/мл-5мл	амп	40	19,800	792,000	40	792,000		-
13	Норэпинефрин 2мг/мл-2мл	амп	140	30,800	4,312,000	140	4,312,000		-
14	Эпинефрин 1мг/мл-1мл	амп	60	946	56,760	50	47,300	10	9,460
15	Парацетамол	тр	80	400	32,000	70	28,000	10	4,000
	Нийт дүн		2,192		13,621,360		13,316,750		304,610

Хуваарь гаргасан: ЭБХЧАБЗХХМэргэжилтэн
 Хянасан: ССБМНБАжилтан

О.Анхбаяр
 Н.Чулуун-Эрдэнэ